# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ЖАМЪЯНГИЙН БАЯСГАЛАНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх ” | | | | | | | |
| 1 | Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөр, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн байгууллагын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг батлуулсан байна. | “Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах явцад хууль, эдийн засгийн үндэслэлийг судалж Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 3-т “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 1-д “Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаар тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан тул дээрх хөтөлбөрийг “Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” болгон дахин өөрчилж боловсруулж удирдлагад танилцуулахаар бэлтгэсэн.<br><br>Хөтөлбөрийг боловсруулах явцдаа Сангийн яам, Гадаадын иргэн харьяатын газар, Барилга хөгжлийн төв, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн хөтөлбөрүүдийг судлан харьцуулсан ба Олон Улсын Валютын Сангийн орлогын удирдлагын зөвлөх Барбара Хеберт гаалийн байгууллага дээр ажиллах үед хөтөлбөрийн төслийг танилцуулан, зөвлөмж авч ажиллаж, төслийг газар, хороодод 2 удаа хүргүүлж, саналуудыг авч нэгтгэн тусгасан.<br><br>Хөтөлбөрийн зорилго нь Гаалийн байгууллагын албан хаагчийн ур чадвар, хөгжил, гүйцэтгэлийг сайжруулах, нийгмийн баталгааны түвшин нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх үйл ажиллагааны | 01.01-06.10 | 90 |

220

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | явцад эрүүл мэнд, амь насыг нь хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно. Мөн "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн төслийг боловсруулан, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодоос санал авч, саналыг нэгтгэж байна. | | |
| 2 | Албан хаагчдыг сэлгэн ажиллуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ шийдвэрлэсэн байдал. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн томилох, чөлөөлөх, дэвшүүлэх сэлгэн ажиллуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>2.Сэлгэн ажиллуулахад шаардлагатай судалгааг гаргаж, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ашигласан байна<br>3. "Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам"-ын дагуу судалгааг гаргах | Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/367 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам"-ын цахим аргачлалын программын даалгаврыг Мэдээлэл технологийн газарт хүлээлгэн өгч, тус газартай тайлангийн хугацаанд 2 удаа нэмэлт санал солилцож хамтарсан уулзалт хийж ажиллаа. Уг журмын хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 20-26-ны хооронд захиргаа, дотоод ажлын систем (CERP)-ээр "Б", "В" бүсэд ажиллаж буй албан хаагчдаас шилжих болон үргэлжлүүлэн ажиллах эсэх хүсэлтийг хүлээн авч холбогдох ажиллагааг хийж удирдлагад танилцуулсан. Тухайлбал: Гаалийн байгууллагын "Б", "В" бүсэд хамаарах 15 гаалийн газар, хорооноос нийт 14 газар, хорооны 147 албан хаагч хүсэлт ирүүлснээс "Б" бүсийн 69 албан хаагч, "В" бүсийн 8 албан хаагч, нийт 77 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах, "Б" бүсийн 32, "В" бүсийн 38 албан хаагч, нийт 70 албан хаагч өөр гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн харин "Б", "В" бүсэд 15 гаалийн газар, хороод багтах бөгөөд одоо ажиллаж байгаа 597 төрийн тусгай албан хаагчдын 25% буюу 147 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах эсвэл харьяа гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн бол "Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам"-ын 3.4-т "Б", "В" бүсэд ажиллаг хугацааг 3 хүртэлх жилээр өөрийн хүсэлтээр сунгаж болно" гэсэн заалтын дагуу үргэлжлүүлэн ажиллах хүсэлт гаргасан 77 албан хаагчийн хүсэлтийг хангах боломжтой байна. Замын-үүд дэх гаалийн газрын үйл ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлсэнтэй холбоотойгоор бүтэц, орон тоог нэмэгдүүлсэн бөгөөд тус орон тоог тусгай шалгалтаар нөхөхийн зэрэгцээ дээрх журмын Б,В бүсэд ажилласан болзол хангаж хүсэлт гаргасан албан хаагчийг судалж, шилжүүлэн томилохоор ажиллаж байна.<br><br>Мөн уг журмын хүрээнд эхний хагас жилд нийт 171 албан хаагчийг харьяа газар, хороодод шилжүүлэн томилсон ба энэ нь нийт албан хаагчдын 11.5 хувь байгаа бөгөөд 2024 онд хийгдсэн ГЕГ-ын бүтэц, | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулалтын өөрчлөлт, албан хаагчийн гаргасан хүсэлт, үүссэн сул орон тоо, ажил мэргэжлийн онцлог, ажлын ачааллыг харгалзан шийдвэрлэсэн байна. | | |
| 3 | Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт, хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, бүрдүүлэх, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт хийж цахим санд мэдээллийг оруулж хувийн хэргийг хадгалах, журмын дагуу ажиллана.<br>2. Албан хаагчдын цалин, нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн болон бусад мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн ХНУМТС-д оруулж санг бүрдүүлж ажиллана.<br>3.Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа хийхэд цахим сангаас мэдээлэл гаргаж боловсруулалт хийж үйл ажиллагаанд ашигласан байна. | Албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдлыг гаргаж, цаашид стандартын шаардлага хангасан өрөө, зориулалтын нягтаршуулсан шүүгээ хувийн хэргийн хавтас бусад хэрэгслийн тухай танилцуулгаар удирдлагад хүргэж, шаардлагатай хөрөнгийн тооцоолол гаргаж 2024 оны төсвийн төсөлд тусгуулж ажилласан. Архивд шилжүүлэхээр 2019-2023 онуудыг хамарсан 320 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарсан 67 албан хаагчийн 30 боть, нас барсан 20 ажилтны 8 боть, ажлаас чөлөөлөгдсөн 215 ажилтны 35 боть, халагдсан 18 ажилтны 6 боть нийт 79 боть хадгаламжийн нэгж баримтыг хүлээлгэн өгсөн. Үндсэн ажлын хүрээнд ХНХ-ийн даргын 2024.04.12-ны өдрийн 01-1.1/1416 дугаартай албан бичгийг харьяа газар, хороодод хүргүүлж, албан хаагчдын 2021-2023 онуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хуудас, сахилга ёс зүй, шагналын баримтын хуулбар бусад материалыг энэ оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлж харьяа 19 газар, хорооны нийт 1466 албан хаагчийн 15925 хуудас материалыг хувийн хэрэгт оруулаа. ГЕГ-ын нэгж, дэргэдэх байгууллагын 1348 албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээний хуудас, нийт албан хаагчийн мэргэшлийн түвшин тогтоох шалгалтын дүнгийн хуудас зэрэг 1189 хуудас материалыг хувийн хэрэгт оруулаа. Гаалийн байгууллагад шинээр ажилд орсон 91 албан хаагчийн хувийн хэрэг нээж, цахим анкетын мэдээлэл үүсгэж ажиллаж байна. Захиргаа дотоод ажлын систем СЕРП-д нийт 1456 төрийн тусгай албан хаагчаас 1380 албан хаагчийн цахим анкетын баталгаажуулалт хийсэн.<br><br>Төрийн албаны зөвлөлийн ХНУМТС- санд гаалийн байгууллагын албан хаагчдын цалин, нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн, Гаалийн ерөнхий газарт /Бүрдүүлэлтийн цахим төв г.м/ 2024 онд томилогдсон 60 албан хаагчийн үндсэн мэдээлэл болон үндсэн цалин, нэмэгдлийн /300 гаран нэмэгдэл/ мэдээллийг тушаалтай хавсарган тус тус оруулаа. | 01.01-06.10 | 100 |

222

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, нөхөн хангалтын байдал, жендэрийн тэгш байдал хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил шаардлагыг хангасан ажилтныг сонгон шалгаруулсан байна.<br>2.Төрийн албаны зөвлөлийн чиглэл, салбар зөвлөлийн тогтоол шийдвэрийг үндэслэн шийдвэр гаргаж ажиллана.<br>3. Жендэрийн тэгш байдлыг хангаж ажилласан байна. | Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөн хангахаар ГЕГ-ын Салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn гаалийн байгууллагын www.ecustoms.gov.mn цахим хуудсаар олон нийтэд нээлттэй зарлаж энэ оны 01 дүгээр сард төрийн бусад байгууллагаас шилжих зараар нөхөгдөөгүй 86 албан тушаалд хамаарах 152 сул орон тоо, мөн 04 дүгээр сард 77 албан тушаалд хамаарах 139 сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, ГЕГ-ын дэргэдэх салбар зөвлөл шалгалтыг зохион байгууллаа.<br>Дээрх 2 удаагийн шалгалтын цахим бүртгэлээр 318 иргэн хүсэлт ирүүлсэн материалыг хянан үзэж, шаардлага хангасан 167 иргэнийг бүртгэж шалгалтад хамрууллаа.<br>Тусгай шалгалтад тэнцсэн нийт 101 иргэнийг тухайн албан тушаалд нь томилуулахаар салбар зөвлөлөөс нэр дэвшүүлснээр, зарлагдсан 291 ажлын байрны 101 буюу 34,7 хувийг нөхсөн.<br>Салбар зөвлөлийн тогтоолоор 101 иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлснээс энэ оны 1 дүгээр сард 59 томилсон /үүнээс өөрийн хүсэлтээр татгалзсан 7, эрүүл мэнд тэнцээгүй учир томилогдоогүй 9/ 7 дугаар сард чиглүүлэх сургалт төгсөж томилогдох 32/ нийт 91 иргэнийг харьяа газар хороонд томилж шийдвэрлэхээр байна.<br>Төрийн албаны тухай хууль болон холбогдох журамд заасан шилжих зарын дагуу төрийн бусад байгууллагаас шилжүүлэн авсан 14 төрийн жинхэнэ албан хаагчид гаалийн улсын байцаагчийг эрх олгож, харьяа гаалийн газар, хороодод томилсон байна. Гаалийн байгууллагын захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд сурч төгсөж ирсэн 1 иргэнийг Сургалтын төвд багш гаалийн улсын байцаагчаар томилсон. Нийт сул орон тооны нөхөн хангалтыг задалж үзвэл Улаанбаатар хотод 14, хөдөө орон нутагт 44 иргэнийг томилж / анх удаа томилогдож буй 18 иргэнийг туршилтын хугацаагаар томилон ажиллуулж/, 32 иргэнийг гаалийн хэргийн мэдлэг олгох богино хугацааны чиглүүлэх сургалтад хамруулсан. Дараагийн сул орон тоог нөхөх шаардлагатай 76 албан тушаалын 146 сул орон тоог зарлаж бүртгэлийг явуулж, шалгалт энэ оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.<br>Гаалийн байгууллагын албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан Жендэрийн талаарх мэдээлэл болон Ажлын байрны бэлгийн дарамт, жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахтай холбоотой гомдлыг хүлээн авах талаарх мэдээллийг CERP системд байршуулсан.<br>Жендэрийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хэрэгжүүлэх жендэрийн стратегийн үнэлгээ”-ний талаар техникийн зөвшилцөх | 01.01-06.10 | 100 |

223

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтад 15 албан хаагчтай хамт оролцсон бөгөөд уг сургалтын хүрээнд Гаалийн байгууллагад Жендэрийн үндэсний хорооноос “Жендэрийн стратегийн үнэлгээ”-г хийхээр боллоо. Тус үнэлгээний хүрээнд Улаанбаатар хот дахь гаалийн газрын 10 албан хаагчтай Жендэрийн үндэсний хорооны зөвлөх ажилтан фокус ярилцлага хийлээ.<br>Харьяа гаалийн газар, хороодод Жендэрийн асуудлыг хариуцах албан хаагчдын судалгааг гаргалаа. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гаалийн байгууллагын дэд салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн батлуулж, Татварын ерөнхий газрын Жендэр хариуцсан ажилтантай уулзаж, туршлага судалсан. | | |
| 5 | Гаалийн байгууллагын нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | 1.Албан хаагчдын шагнал, урамшуулал, зэрэг дэв цолны судалгаа, танилцуулга хийж шийдвэрлүүлж ажиллана.Мөн цалин хөлс, тусламж, тэтгэмж, тогтоолгох ажлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.<br>2. Ахмад настнуудтай хамтран ажиллах журам батлах, ахмад настнуудын судалгаа бүртгэл хийж журмын хэрэгжилтийг хангасан байна. | Албан хаагчдын нийгмийн асуудлыг хангах чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлсэн.Үүнд:<br>Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэхээр ГЕГ, дэргэдэх байгууллага, харьяа газар хороодын 367 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоох жагсаалтыг гарган СХОГ-т хүргүүлсэн.<br>-Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох, гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу ГЕГ, дэргэдэх байгууллагын 284 албан хаагчийн нэмэгдэл олгох жагсаалтыг СХОГ-т тус тус хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>-Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2-т заасны дагуу харьяа гаалийн газар, хороодод журамд заасан шаардлага, шалгуур хангасан албан хаагчдад зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах саналыг энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд саналыг нэгтгэж удирдлагад танилцуулан шийдвэрлэсэн.<br>-"Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу 2024 онд 13 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарах хүсэлтийг шийдвэрлэж 484.1 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон.<br>-Ар гэрийн гачигдал тохиолдсон 43 албан хаагчид 28,3 сая төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан 4 албан хаагчийн ар гэрт 50,9 сая төгрөгийн нэг удаагийн тусламж,<br>- Гаалийн тухай хуулийн 280.7 -д УБ хотоос бусад гаалийн газар, хороодод тасралтгүй 5 жил ажилласан албан хаагчид 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох зохицуулалтыг УИХ-аар батлуулж, арга хэмжээ авч | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлснээр нийт 482 албан хаагчид 6.7 тэрбум төгрөгийн тэтгэмж олгож шийдвэрлүүллээ.<br>Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан албан хаагчдыг шагнаж урамшуулахаар санал нэгтгэлийг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүллээ.Үүнд:<br>Сангийн яамны жуух-45<br>Гаалийн албаны тэргүүний ажилтан -20<br>Хөдөлмөрийн хүндэт медаль-72<br>Алтангадас одон-26<br>Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон -21<br>Нийт 184 албан хаагчийн нэрс, холбогдох материалын хамт 2024.06.18-ны өдрийн 01/2466 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв. | | |
| 6 | Хүний нөөцийн хэлтэс гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Албан хаагчдын гаргасан хүсэлт, гомдлыг удирдлагад танилцуулж, хуулийн хугацааны хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хүний нөөцийн хэлтэст хуваарилагдсан ирсэн бичиг 596, явсан бичиг 269, өргөдөл хүсэлт 273 /шийдвэрлэсэн 244, шилжүүлсэн 32, судалж байгаа 29, хугацаа хэтэрч хариу өгсөн 11, хугацаа дөхсөн 3/ хуулийн хугацаанд хариуг өгч ажилласан байна. | 01.01-06.10 | 100 |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ажил үүргийн дагуу ажилласан байна. | Гаалийн байгууллагын 2023 оны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, боловсруулж, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн, хуулийн хугацаанд тайлагнаж, дүгнүүлсэн. | 01.01-06.10 | 100 |
| 8 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийн байдал. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Төрийн албаны , Хөдөлмөрийн тухай, Гаалийн тухай хууль, бусад нийцүүлэн гаргасан журам эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан байна. | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 9 | Цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | 1.Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангасан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/183 дугаартай Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 2018-2023 оны хооронд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа газар, хэлтэс, төвийн дарга /давхардсан тоогоор 53/ нарын мэдээлэл болон анкет, тушаалын хуулбарыг нотлох баримтын шаардлага хангуулан 418 хуудас баримтыг хүргүүлсэн. | 01.01-06.10 | 100 |

225

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2. Онлайн болон Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хангасан байна.<br>3.Удирдлагаас болон Сэрп системээр өгсөн үүрэг даалгаврыг хангасан байна. | УИХ-ын дэргэдэх хяналтын түр хорооноос ирүүлсэн албан бичгийн хүсэлтийн дагуу Эм био бэлдмэлийн хяналт хариуцсан 17 албан хаагчийн анкет, ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаал, албан тушаалын тодорхойлолтын хуулбар бүхий 138 хуудас материалыг хүргүүлэв. Сэрп системээр өгсөн үүрэг даалгаврыгтогтоосон хугацаанд цаг алдалгүй биелэлтийн хүргүүлэн ажилласан. | | |
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Тус хэлтсийн албан хаагчид цаг ашиглалтыг баримтлаж чөлөө, хүсэлтийг цахимаар бүртгэлжүүлж зөвшөөрөл авч ажилласан байна. | Цаг ашиглалтыг гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтын дагуу мөрдөж ажиллаж байна. Ажлын цагийг нүүр таних төхөөрөмжөөр бүртгэл үүсгэсэн. Ажилтан аливаа чөлөө авах тохиолдолд нэгжийн удирдлагад бичгээр хүсэлт гарган мэдэгдэж, зөвшөөрөл авч ажилласан. Эхний хагас жилийн байдлаар тасалсан, хоцорсон ямар нэгэн зөрчилгүй байна. | 01.01-06.10 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Төрийн албаны зөвлөлийн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийг байгуулах асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,<br>2.Шийдвэрлэгдсэн тохиолдолд төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон шуурхай ажиллах, | Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой ажлаар ГЕГ-ын нэгжүүдтэй 176 дотоод зурвасаар, харьяа газар, хороотой 270 гаруй албан бичгээр хамтран ажилласан байна.<br>Хүний нөөцийн үйл ажиллагааны явцад бий болсон 2018-2022 онуудын баримт бичгүүд, 2023 оны тус нэгжийн хөтлөх нэрсийн жагсаалтын дагуу баримт бичгийг төрөлжүүлэн архивын нэгж үүсгэж, байгууллагын архивд шилжүүлэн өгөв. Үүнд:<br>2018 оны Ирсэн бичиг-1 боть , 2021 оны ирсэн бичиг-1 боть, 2022 он баримтын 7 боть хадгаламжийн нэгж, 2023 оны баримт бичгийн 33 боть хадгаламжийн нэгж үүсгэсэн. Үүнд: ГЕГ-ын даргын Б тушаал-6 боть, А тушаал-6 боть, ирсэн бичиг- 3 боть, ирсэн дотоод зурвас -4 боть, явсан дотоод зурвас -2 боть, өргөдөл хүсэлт-3 боть, албан хаагчийн Шагналын материал-1 боть, Нээлттэй хэлэлцүүлгийн материал-1 боть, ЗХЭГ-ын "Шүүр" ажиллагааны хүрээнд хийгдсэн материал-3 боть, ТАЗ-ийн ГЕГ-ын Салбар зөвлөлийн тусгай шалгалтын 4 боть байна. | 01.01-06.10 | 100 |

226

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна. | ЗГХЭГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 албан бичгээр 11 чиглэлд арга хэмжээ авч ажиллав. Үүнд:<br>Гаалийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгөөгүй 60, тусгай шалгалт өгөөгүй 88 албан хаагч нийт нийт 149 албан хаагчийг нөхцөл байдлыг тогтоосон.Тус албан хаагчдыг ажлаас чөлөөлж шалгалтад бэлтгэж, хамруулах ажлыг дэс дараатай зохион байгуулж одоогоор 107 буюу 71.8 хувь нь хууль ёсны томилогдов/<br>Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлага буюу мэргэжил, мэргэшил, туршлага, боловсролын шаардлага хангасан албан тушаалтнуудыг мөн 2019 оноос хойш хугацааг хамруулсан байдлаар судалгааг гаргав.<br>Авлигатай тэмцэх газраас ашиг сонирхлын зөрчилтэй байдал тогтоогдсон зөрчил үүсэх нөхцөлтэй томилсон албан хаагчийн судалгаа хийхэд албан тушаалд томилох, сэлгэн ажиллуулахдаа албан хаагчийн ХАСУМ-хянуулсан байдалд АТГ-аас 2019-2022 оны ирүүлсэн дүгнэлтэд судалгаа хийж, 25 албан хаагч дээр ирүүлсэн дүгнэлтэд холбогдох тайлбар, лавлагаа гаргууллаа мөн 5 албан хаагчид сахилгын арга хэмжээ авч албан тушаал бууруулан сэлгэн ажиллууллаа.<br>Мөн 2019-2022 онд “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон давхардсан тоогоор 462 албан хаагчийн судалгаа гаргалаа.<br>Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх судалгааг гаргав.Үүнээс Гаалийн байгууллагад ажиллаж буй нийт 1445 албан хаагчдаас иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон байгаа эсэх талаарх судалгааг авч нэгтгэн үзэхэд Эрүүгийн хариуцлага хүлээж байсан-33, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа-5, хуулийн байгууллагад шалгагдаж байж болзошгүй 13 албан хаагчийн судалгааг гаргасан энэ мөрөөр ГЕГ-ын даргын “Чиглэл хүсэх тухай” 01/1285 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Төрийн албаны зөвлөлд хандсан.Энэ тухайд Төрийн албаны зөвлөлийн 2023.05.17-ны 03/1145 тоот албан бичгээр тус зөвлөлөөс дараах | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэл иргүүлээд байна энэ тухай Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлсэн буюу 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруут шүүх тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон нөхцөлд төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд нийцүүлж албан тушаалаас нь халах зохицуулалттай тухай хариуг иргүүлсэн.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон зэрэг судалгааг гаргахад 2022 онд нийт 106 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан ба үүнээс тухайн жилдээ 2 удаа сахилгын шийтгэл хүлээсэн 3 албан хаагч байна.<br>Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага, мэргэжил тохирч байгаа эсэх судалгааг гаргахад албан тушаалын тусгай шаардлагад огт байхгүй 8 төрлийн мэргэжлийг гаргаж “Төрийн албаны зөвлөл”-д чиглэл авах зэргээр дээрх ажлын хүрээнд Засгийн газар, Сангийн яам, Төрийн албаны зөвлөлд танилцуулж хамтран ажиллаа.<br>Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ажлын хэсэг ирж дээр шүүр ажиллагааны үр дүнг нягтлах, шалгах зорилгоор ГЕГ-дээр 15 хоног ажиллав.Уг ажлын хэсэгт мөн нийт албан хаагчдын хувийн хэрэгт авагдсан материалыг ГЕГ-ын нийт ажилтнууд болон харьяа газар, хороодын удирдлагуудын хувийн хэрэг болон захиргааны шийдвэрүүдэд үзлэг хийж зөвлөмж өгч ажиллаа. | | |
| 2 | Судалгаа, лавлагааны талаар үүрэг даалгавар | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | | Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхээр 75 төрлийн судалгааг Захиргаа дотоод ажлын программаас гаргаж, үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, УИХ-ын хяналтын түр хороо, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Ажлын хэсгүүдэд ажлын шаардлагаар албан хаагчдын хувийн хэрэгт авагдсан материалыг хуулбарлах, танилцуулга мэдээлэл бэлтгэх, албан тушаалын тодорхойлолт, ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаал, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг олон тооны материалыг баримт бичгийн шаардлага хангуулж баталгаажуулан хүргүүлж ажиллаа.Үүнд: Гашуунсухайт, Шивээхүрэн гаалийн газрын 2010-2022 онд ажиллаж байсан дарга, албаны дарга, ГУАБ, ГУБ, ГЕГ-ын 2004-2023, 2015-2022 онуудад ажиллаж байсан дарга, дэд дарга, удирдлагын зөвлөлийн гишүүд, Замын-Үүд, УБГГ, ЧХОУНБ гаалийн газрын нэр бүхий гаалийн улсын байцаагч нарын талаар судалгаа | 01.01-06.10 | 100 |

228

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулгыг холбогдох газар, албан тушаалтнуудад хүргүүлэв. Хувийн хэрэгт авагдсан материалыг чиглэлээр бүрдүүлэхдээ байгууллагын болон тухайн харьяа газар, мөн улсын архиваас бүрдүүлэх замаар ачаалалтай ажиллав. Тухайлбал хамрах хугацаа, албан тушаалтан бүрээр дээр дурдсан материалыг 1 хүнд 7-25 хүртэл хуудас нийт 200 гаруй хүнд 3000 гаруй хуудастай материалыг хуулбараар хүргүүлж ажилласан байна. | | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Нэгжийн албан хаагчдыг сургах, чадавхжуулах чиглэлээр | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зохих сургалт мэдээлэлд хамрагдсан байна. | Хүний нөөцийн чиглэлээр ажлын мэргэшил чадвараа дээшлүүлэхээр ГУБ Б.Мөнхтуул Б.Батчимэг нар Удирдлагын академиас энэ оны 05 дугаар сарын 27-30-ны хооронд зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь: Хүний нөөцийн удирдлага” сэдэвт 40 цагийн цахим, танхим хосолсон сургалтад хамрагдсан.<br>HR consulting firm байгууллагаас зохион байгуулдаг хүний нөөцийн чиглэлийн 4 удаагийн цахим сургалтад хамрагдсан.<br>Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн 11 удаагийн цахим сургалтад Хүний нөөцийн хэлтсийн ажилтнууд хамрагдсан.<br>БНСУ-д зохион байгуулагдсан Хүний нөөцийн удирдлагын сургалтад ГУБ Б.Батчимэг хамрагдсан байна. | 01.01-06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............................ /Ж.БАЯСГАЛАН/

229

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ЖАМЪЯНГИЙН БАЯСГАЛАНГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хүний нөөцийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 62.8 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалт, байгууллагаас зохион байгуулсан сургалт, мэдээлэлд хамрагдах | | 13 |
| 2 | | | |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 13 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 15 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 14 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4 | Манлайлах | 14 |
| 5 | Багаар ажиллах | 14 |
| 6 | Харилцаа | 15 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | 14 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 14 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 62.8 |

| | | |
|---|---|---|
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 14 |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 89.8 |

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захирагч**

.................................. (Р.Отгонжаргал)

2024.06.19 ............................ (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Нэгжийн дарга:**

.................................. (Ж.Баясгалан)

2024.06.22 ............................ (огноо)